

Бүлэг: Хувь хүн ба соёл
Сэдэв: Би юу хийж бүтээж чадах вэ?

Хамрах хүрээ: 7 анги



Хүний хандлагын талаарх гурван онол

Хүний хандлагын талаарх гурван онол

УДАМШЛЫН ОНОЛ	ОРЧНЫ ОНОЛ	СЭТГЭЛ ЗҮЙН ОНОЛ
"Удамшил намайг бий болгодог."	"Орчин намайг бий болгодог."	"Миний сонголтууд намайг бий болгодог."



Удамшлын онол

- Удамшлын онол нь тухайн хүний ааш зан үеэс үед удамшдаг гэж үздэг.
- Энэхүү онолын сул тал нь хүмүүст өөрийгөө өмөөрөх шалтаг болж өгдөг.
- Жишээ нь: Манай өвөө түргэн ууртай хүн байсан. Аав маань ялгаагүй мөн би ч бас түргэн ууртай. Иймээс миний энэ зан засагдахгүй.

Орчны онол

- Орчны онол нь хүний ааш зан удамшаад зогсохгүй тухайн хүний өссөн орчин, гэрийн хүмүүжил, найз нөхөд гэх мэт гадны орчны нөхцөл байдал тухайн хүний төлөвшилд нөлөөлдөг гэж үздэг.
- Үүнээс үзэхэд удамшлын онол болон орчны хүчин зүйлүүд таныг хэн болохыг тодорхойлоход үүрэг гүйцэтгэдэг.


Сэтгэл зүйн онол

Хүнийг шоронд хорьж, гэр бүлийг нь хөнөөж, өөрийг нь тамлэн зовоосон ч тухайн хүн үүнд хэрхэн хандахаа зөвхөн өөрөө л шийднэ гэсэн үг. Түүний онолоор таны хэн байх нь удамшлын болон орчны нөлөөллөөс илүүтэйгээр таны өөрийн сонголтоос шалтгаалдаг.




Сэтгэл зүйн онолыг баримталдаг байх

- Сэтгэл зүйн онолыг баримталдаг хүмүүс нөлөөнд автахгүй бусдаас өөрөөр сэтгэдэг.
- Сэтгэл зүйн онол нь хоёр зарчим дээр суурилдаг.
 - I. Танд юу ч тохиолдсон гэсэн та юу хийхээ өөрөө сонгох эрхтэй.
 - II. Таны ирээдүй бол таны сонголтын шууд үр дүн.



Сэтгэл зүйн онолыг баримталдаг байх



ХАР

- I. Та юу хийхээ өөрөөл сонгоно
- II. Таны ирээдүй бол таны сонголтын үр дүн

ХИЙ

- I. Санаачилга гаргах
- II. Эерэг үг хэллэг хэрэглэ
- III. Өөрийн нөлөөллийн хүрээгээ өргөжүүлэх
- IV. Сөрөг дадлуудаа хаях
- V. Дондолтоос сэргийлэх

ХҮРТ

- I. Таны хүссэн ирээдүй

Гомдлоо тайлсан нь

- Энэ сургамжит өгүүллэгийг уншиж ойлгоод сонирхолтой асуулт зохиогоод бусдаасаа асуугаарай. Сурах бичгийн 28 хуудас
- Өгүүллэгээс өөрийнхөө амьдралд санаж явах ямар чухал сургамж авсан бэ бусад найзуудтайгаа хуваалцана уу?
- Дэвтэртээ тэмдэглээрэй.

Эерэг хандлага

№	Жишээ:	Өөрийн үйлдэл болон хэлэх үгээ эерэг хандлагын үүднээс бичээрэй
1	Танихгүй хүүхэд гудамжинд хог хаяж, мөн чамайг шоолов.	
2	Хөл бөмбөг тоглож байгаад найз чинь чамайг санамсаргүй унагаав.	
3	Найз чинь чамайг доромжилж гомдоожээ.	

Эерэг сэтгэлгээ ба эерэг хандлага

Хүний эерэг сэтгэлгээ нь аливаа зүйлийн сайн сайхан тал, аливаа бэрхшээлийг даван туулах арга замыг харж чаддаг. Харин сөрөг сэтгэлгээ нь дутагдалтай талыг нь олж хардаг учраас хүний амжилтийг сааруулж байдаг.

Иймээс бид эерэг сэтгэлгээг бий болгож хөгжүүлэхийн тулд бусдын соёлыг ойлгож, хүндэтгэх ёстой.

Бид бусдын соёлыг хэрхэн ойлгож, хүндэтгэх ёстой вэ?

Соёлтой хүн гэж ямар хүнийг хэлэх вэ?

- Бусад хүний үнэлэмж хэрэгцээ, сонирхол, итгэл үнэмшилд хүндэтгэлтэй хүлээцтэй ханддаг. Тухайн хүнтэй эелдэг найрсаг, хүлээцтэй харилцаж, тусалдаг, уучилдаг, бие биеэ дэмждэг байх зэрэг хандлагуудыг эрхэмлэдэг хүнийг хэлнэ.

Соёлын олон янз байдал

Хэл уламжлал, ёс
заншил

Шашин шүтлэг

Урлаг дуу хөгжим

Баяр ёслол



ДҮГНЭЛТ

Хүн төрсөн цагаасаа эхлэн ямар нэгэн соёлын орчинд амьдардаг. Энэхүү соёлоо бид хайрлан хамгаалж, хүндэтгэн дээдэлж, өвлөн авч, бүтээн босгож байх хэрэгтэй.

Хувь хүн бүрт дотоод хүч байдаг. Тухайн дотоод хүчний нөлөөгөөр өөрийн соёлыг, орчны соёлыг бий болгож, аливаа зүйлийг бүтээн босгож, хөгжүүлж амьдардаг.

Гэрийн даалгаварт

□ Өнөөдрийн мэдлэгээ ахин бататгаж сайтар уншаарай.

“Би соёлыг хэрэглэгч бас бүтээгч мөн” гэсэн санааг нотлох жишээ бичнэ үү.